

ЗАЯ БАНДИД НАМХАЙЖАМЦЫН ОРЧУУЛГЫН ХЭЛ НАЙРУУЛГЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Д.Бүрнээ¹⁵

Аннотация: Научному кругу известно, что перу создателя ясного письма ойратскому просветителю- буддисту Зая пандиту Намхайжамцу (1599-1662) и его ученикам принадлежит 177 переводов с тибетского языка на монгольский. Язык перевода Зая пандиты отличается дословностью и верностью тибетскому тексту. В этой статье мы рассматриваем примеры из переводов таких буддийских сочинений как “Дамمامука” (Море притч), “Важрачедика” (Алмазная сутра), “Субхашиктаратнинидхи” (Драгоценная сокровищница назидательных речений). Изучение языка переводов Зая пандиты, а именно особенности стиля, лексические варианты, нюансы переводческой деятельности крупного просветителя дают нам возможность проследить ход истории традиционного монгольского перевода, оценить вклад Зая пандиты в переводческую мысль монголов, а также изучить историю развития ойратского диалекта.

Түлхүүр үг: Ойрад аялгуу, үгчилсэн орчуулгын дэг, орчуулгын хэл найруулга, орчуулгын оновчтой шийдэл

Халх, буриад, ойрад зэрэг өөр өөр нутгийн аялгуугаар харилцах монголчууд нэг бичгийн хэлээрээ нэгдэж ирсэн түүхтэй. Эрт цагт бүрэлдэн тогтсон монгол бичгийн хэл нь 14 дүгээр зуунаас өмнө туульс, түүх бичлэг, албан хэргийн хэлний үүрэг зонхилон гүйцэтгэж байсан бол 14 дүгээр зуунаас эхэлж, буддын утга зохиолын хэлний үүргийг голлон гүйцэтгэх болжээ. Монгол бичгийн хэл түүхэндээ хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж иржээ. Б.Я.Владимирцов монгол бичгийн хэлний хөгжлийн эхэн үеийг 14 зуунаас өмнө, 2 дахь шатыг 14 дүгээр зуунаас хойш хамааруулан үзжээ. Харин 16 дугаар зууны сүүл, 17 дугаар зууны эхэн үеэс хөгжлийнхөө 3 дахь шатанд орсон гэж үзэв. Сүүлийн гурав дахь шатанд монголын соёлын амьдрал идэвхжиж, шашин суртал сэргэсэн нь монгол бичгийн зөв бичих зүй, үг зүй, найруулгыг журамласан “сонгодог” бичгийн хэл бүрэлдэн тогтоход нөлөөлжээ.

Судрын хэл буюу сонгодог бичгийн хэл хөгжихөд буддын шашны агуулгатай төвөд утга зохиолын орчуулга том түлхэц болов. Энэхүү орчуулгын дийлэнх хувийг монгол бичгээр бичиж тэмдэглэсэн нь нийт монголчуудад бурханы сургаал номыг дэлгэрүүлэхэд чухал хүчин зүйл болжээ. Учир нь монголчууд түүхэндээ олон бичиг үсэг хэрэглэж ирсэн боловч хамгийн урт удаан хугацаанд, өргөн дэлгэр хэрэглэгдэж ирсэн бичиг бол худам монгол бичиг билээ. Уйгаржин бичгийг үндэс болгосон монгол бичиг хөгжлийнхөө явцад амьд хэл

¹⁵ МУИС, ШУС, ХУС-ын МХХШТэнхимийн профессор, доктор

аялгууны нөлөөг ямагт тусгаж иржээ. Монгол бичгийн нэг үсгээр хэд хэдэн авиаг тэмдэглэх онцлог нь олон монгол аялгуутныг бичиг үсгээр нь нэгтгэх үүрэг гүйцэтгэхийн сацуу, хэл аялгууныхаа онцлогийг хадгалж, өөр өөрийнхөө замаар хөгжих боломжийг олгожээ (Шагдарсүрэн Ц, 2017, 333). Гэтэл дөрвөлжин бичиг бол ордны язгууртны хүрээнд хэрэглэгдэж, тод бичиг бол ойрад аялгуутны хэл ярианы онцлогийг тусгасан буюу явцуу хүрээнд хэрэглэгдэж байсан учир бичгийн хэлний голлох үүргийг монгол бичигт суурилсан бичгийн хэл гүйцэтгэх болсон байна. Өөрөөр хэлбэл, монгол бичиг монголчуудыг бичгээр бас хэл аялгуугаар, шашин соёлоороо нэгдэх үүргийг олон зууны туршид гүйцэтгэж чаджээ. Тиймээс ч монгол бичгийн дурсгал тоо хэмжээ хамрац, агуулга, хэрэглээний хувьд нэн үлэмж юм (Шагдарсүрэн Ц, 2017, 331). Монгол бичгийн дурсгалын нэгээхэн хэсэг болох судрын орчуулга буюу төвөд хэлнээс орчуулсан бурханы шашны ном судрын дийлэнх хувь монгол бичгээр уламжилж ирсэн байна. Эдгээр орчуулга халх, буриад, ойрад, өвөр монголд түгэн дэлгэрч байсныг монгол орны хот хөдөө төдийгүй дэлхийн бусад оронд хадгалагдаж буй олон зүйлийн гар бичмэл, барын эх судрууд гэрчилнэ.

Бие, хэл, сэтгэлээ сахиж, аливаа нүглийг тэвчиж, буян хураахыг номлодог бурханы шашны сургаалыг эх монгол хэлнээ хөрвүүлж, нийт монголчуудад түгээн дэлгэрүүлэх үйлсэд Хөх хотын Ширээт гүүш, урад гүүш Билгүүндалай, цахар нутгийн Лувсанчүлтэм, халхын гүүш Алтангэрэл, Гэлэгжамц, буриадын Төгөлдөрийн Галсанжамба, Дэлгэрийн Галсанжамба, Сумадираднаа буюу Номтын Ринчен, ойрадын Зая бандид Намхайжамц нарын олон дуун хөрвүүлэгчид тэргүүлэн оролцож байсан билээ.

Судрын орчуулгын түүхэнд нэг зохиолын хэд хэдэн орчуулга дэлгэрсэн байна. Тухайлбал, төвөд хэлээр “Занлүндө”, монголоор “Үлгэрийн далай” хэмээх бурханы шашны уран зохиолын дурсгалын дөрвөн орчуулга, шашин гүн ухааны “Найман мянгат”, иргэний яруу найргийн “Субашид” зэрэг зохиолын тус бүр арав орчим орчуулга уламжлан иржээ. Нэг зохиолын олон орчуулга гарсан нь өргөн уудам нутагт тархан суусан монголчууд нутаг нутагтаа орчуулгаа хийж байсантай холбоотой. Бас өмнө гарсан орчуулгыг улам боловсронгуй болгох, шашин номыг улам дэлгэрүүлэх ч зорилготой байжээ (Шагдарсүрэн Ц, 2001, 116). Эдгээр орчуулгаас бид нутаг нутгийн онцлог ялгаа хэрхэн туссаныг ажиглах бүрэн боломжтой. Нөгөөтээгүүр судрын тэг зурлага, бичгийн цаас тэргүүтэн ч бас аль нутгаас гаралтайг ажиглах боломж өгнө.

Судрын орчуулга худам монгол бичгээс гадна тод бичгээр уламжилж ирсэн билээ. Тод бичгийг Зая бандид Намхайжамц 1648 онд ойрад аялгууны онцлогийг тэмдэглэхэд зориулж зохиосон бөгөөд монгол бичгийн нэг үсгээр хэд хэдэн авиаг тэмдэглэж байсныг тод бичигт өөр өөр үсгээр ялган тэмдэглэжээ. Зая бандид Намхайжамц өөрийн зохиосон бичгээр 1656-1662 оны хооронд шавь нарын хамт 177 ном орчуулсан байна. Түүний орчуулсан дийлэнх ном бурханы шашны утга агуулгатай судар болно. Энэ орчуулга бол монгол бичгийн орчуулгын хөрвүүлэг биш харин бие даасан орчуулга бөгөөд ойрад аялгууны онцлог шинжийг тусгасан болно.

Тод үсгийг манай улсын ойрадууд буюу дөрвөд, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошуудууд сүүлийн үе хүртэл хэрэглэж байжээ. Одоо тод үсгийг Шинжааны ойрадууд хэрэглэж байна. Цаг хугацааны тухайд 17 дугаар зуунаас өнөө үе хүртэлх үеийг хамарч байна.

Ойрадын бичиг соёл уламжилж ирсэн нь тод бичигтэй салшгүй холбоотой. Ойрад хэл аялгууны дуудлагыг тэмдэглэсэн бичиг үсэг боловсруулж түүгээр ном судар орчуулж байсан нь энэ аялгуутны соёлын өвийг хадгалах нөхцөлийг бүрдүүлжээ. Тиймээс аливаа нутгийн аялгууг устаж үгүй болохоос хамгаалах зүйлийн нэг бол яах аргагүй бичиг үсэг болохыг тод бичгийн орчуулга харуулж байна. Тод үсгийн дурсгал бол ойрад аялгууны түүхийг судлах сурвалж мөн тул тод үсгээр уламжилж ирсэн орчуулгыг судлах нь мөн ойрад аялгуу болон монгол хэлний хөгжлийн эрт үеийг судлахад чухал үүрэгтэй болохыг судлаачид тэмдэглэсээр иржээ. Монгол бичгээр уламжилж ирсэн дурсгал, сурвалж бичгийг судлахад ойрад аялгууны үүрэг их билээ. Бид энэхүү өгүүлэлдээ Зая бандид Намхайжамцын зарим орчуулгын хэл найруулга болон үгсийн сангийн зарим онцлогоос өгүүлэх юм.

Төвөд хэлээр “Занлүн”, монголчуудын дунд “Үлгэрийн далай”¹⁶ хэмээн алдаршсан судрын дөрвөн зүйлийн орчуулга уламжилж ирсний нэг нь Зая бандид Намхайжамцын орчуулсан “Мэдээтэй мэдээгүйг ялгагч” нэртэй судар болно. Тус орчуулгад төвөд бичгийн хэлний найруулгыг хуулбарлан буулгасан онцлогтой. Энэ нь Зая бандидын орчуулгадаа баримталж байсан арга зарчимтай холбоотой. Өөрөөр хэлбэл, шашин номын утга санааг хөдөлбөргүй үнэн буулгах зорилгодоо хөтлөгдөн өгүүлбэрийн бүтцийг хуулбарлан буулгахад хүрч байсан байна. Тухайлбал,

Төвөд эх:

Rgyal po de shin tu snying rje dang ldan pas mi la sogs pa skye bo mang po bde skyid cing 'byor ba dang, bde ba dang lo legs par ldang te, rgyal po de skye bo mang po 'i pha ma lta bur gyur te

Зая бандид:

Тэр хаан өршөөнгүй маш төгссөний тул хүмүүн тэргүүтэн олон төрөлхтөн аман жарган учралтай, амгалан, он сайн болон тэр хаан маш олон төрөлхтний эцэг эх мэт болвай (Бүрнээ Д, 2003, 75). Энэ өгүүлбэрт 2 удаа давтагдсан *skye bo mang po* хэмээх үгийг мөн давтан “олон төрөлхтөн” гэж буулгажээ. Төвөд хэлний тодотгол гишүүн тодотгуулагчийн хойно орох зарчмыг хуулбарлан *lo legs par* гэсэн хэллэгийг “он сайн болон” хэмээн хөрвүүлжээ.

Зая бандид үгчилсэн орчуулгын дэгийг тогтоосныг харуулах жишээ олон бий. Тухайлбал, *khyim thabs kyis smras pa, bdag ni chu gang dang khrel stas kyis 'tsho ste, rdzun mi zer bas rgyal pos kyang zhal che bar bcug go.*

Зая бандид:

Гэрийн эзэн өгүүлэв би ус дүүрэн хийгээд жигшихүйгээс цээрлэхүй бээр ану

¹⁶ “Шулуун онолт” хэмээн Ширээт гүүшийн орчуулсан судар монголчуудын дунд “Үлгэрийн далай” нэрээр алдаршжээ. Зүүн авгын Цүлтэмлодой, Тойн гүүш нарын орчуулга бас бий.

худал үл өгүүлэх тул хаан ч заргач болгов.

Ширээт гүүш:

Тэр заргач ноён өгүүлрүүн, би ичгүүрт болоод төр ёсыг сэтгээж худал эс өгүүлсний тулд хаан ч заргач болгов.

Төвөд эхийн доогуур нь зурсан *chu gang* гэсэн хэллэгийг үгчилж буулгавал “ус дүүрэн”, харин утгаараа “авир аальт”, “их зоригтой” гэсэн үг бөгөөд Зая бандид түүнийг хуулбарлан буулгасан учир ойлгомжгүй болсон байна.

Ширээт гүүш энэ үгийг “ичгүүрт болоод” гэж хөрвүүлсэн нь оножээ. Түүнчлэн “sems can dang ldan par gyur” гэснийг Зая бандид “амьтантай болов” гэсэн бол бусад орчуулгад “жирэмсэн болжухуй” (Цүлтэмлодой), “урагтай болвай” (Тойн гүүш), “шалтагтай болвай” (Ширээт гүүш) гэжээ.

Зая бандидын орчуулгад зарим оноосон нэр, нэр томьёо, хэлний зүйн хэлбэрийг ялгаа зөрөөтэй орчуулжээ. Тухайлбал,

№	Төвөд үг хэллэг	Бусад орчуулга	Зая бандидын орчуулга
1	bcom ldan ‘das	ялж төгс нөгчсөн	илагун төгсөн үлсэн
2	mya ngan las ‘das	нирваан бол-	гаслангаас нөгчи-
3	yang	бээр	ч
4	rgyal mtshan	туг	ялгуусан бэлгэ
5	bdag la	надур	нада
6	bu	хөвгүүн	хүүхэн
7	byang chub sems pa	бодисун	бодхисатва
8	mnyan yod	Ширабасун, Ширавасда	Сонсохуйн буйд
9	dge slong	аяга тэхимлиг	гэлэн
10	bsod nyoms	бинвад	тэгш буян

Уламжлалт орчуулгад санскритаар сэргээн буулгаж орчуулдаг уйгар орчуулгын зарчмыг Зая бандид дагаж мөрдөөгүй болохыг 8, 9, 10-р жишээнээс харж болно. Уламжлалт орчуулгаас бас ялгаатай хөрвүүлсэн сул үг (3-р жишээ), нэр томьёо (1, 2, 4-р жишээ) тэргүүтний орчуулгыг ажиглавал төвөд эхийн хэлний зүйг хуулбарлан буулгахыг зорьсон болох нь харагдана. Харин 5-р жишээний тухайд ярианы хэлэнд илүү ойр буулгажээ.

Зая бандидын орчуулгад ойрад аялгууны онцлогийг илтгэсэн “эхнэр”-ийг “найжинар”, тагтаа шувууг “хөгөлжиргөнө”, “эгэм”-ийг “ээм”, “хавирга”-ыг “хабусун”, “булаг”-ийг “буулаха”, “туулах” гэхийг “дуусах”, “зоос”-ыг “тэнгэ” гэх зэрэг үг хэллэг олон бий.

О.Дэмчигмаа “Субашид”-ын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог” номдоо Зая бандидын орчуулга дахь ойрад аялгууны 24 үгсийг бүртгэн тайлбарлажээ. Тухайлбал, тус орчуулгын 298-р зүйлд төвөд хэлний “lham” хэмээх үгийг “годос” (godosu) гэж орчуулсныг дурдаад тус үг “Монголын нууц товчоо”-ны 114, 145-р зүйлд бас байх бөгөөд ойрад, Алшаа, Хөхнуур зэрэг нутгийн аман аялгуунд хадгалагдан үлдсэн гэжээ (Дэмчигмаа.О, 2013, 57). Ц.Шагдарсүрэн “годос” гэдэг үг Тойн гүүшийн орчуулгад бас тааралдаж байгааг тэмдэглэжээ (Шагдарсүрэн Ц, 2017, 132). “Субашид”-ийн Зая бандидын орчуулгын 173-р зүйлд

төвөд хэлний “bcos” хэмээх үгийг “ясаж, ясахула” гэж тэмдэглэжээ (Дэмчигмаа О, 2013а, 59).

Судрын орчуулгаас гадна иргэний яруу найргийн зохиол болох “Субашид”-ийг хэрхэн орчуулсныг авч үзье. “Субашид”-ийн 111 дүгээр бадагт:

‘byor ba’i dus na thams cad gnyen
Gal te gud na kun kyang dgra
Rin chen gling du ring nas ‘du
Mtsho bskams pa na su yang spong

Энэ бадгийг Зая бандид орчуулсан нь:

Баян цагт хамаг ураг
Хэрвээ буурхулаа (буурвал) хамаг ч дайсан
Эрдэнэ тивд нь холоос хурмуй
Нуур нь хатваас хамгаар тэвчмүй (Дэмчигмаа О, 2013б, 83)

Энэ бадгийн утга бол аливаа хүн чадалтай тэнхээтэй явахад садан нөхөр мундахгүй олон байх боловч ядарч доройтох цагт холдож явах хүн олон болохыг үнэт эрдэнэсийн аралд хаа холоос хүн хуран чуулах атал ширгэсэн нуурыг хэн ч болов алсуур тойрон өнгөрдөг гэж буй. Зая бандид ийнхүү буулгахдаа монгол шүлгийн зарчмыг баримталж толгой холбож, уран яруу буулгахыг чухалчилсангүй. Харин үг бүрийг чанд буулгаж, сул үгийг ч орхиж гээлгүй хөрвүүлэхийг зорьжээ. Мөнхүү бадгийг Цахар нутгийн гэвш Лувсанчүлтэм толгой холбож уран яруу орчуулсан нь:

Сайжран дээшлэхүй цагт бүгд эргэцэн нөхөр болох
Сааран доройтох цагт бүгд дутаан дайсан болох
Сайн эрдэнэт далайн хойгт олон худалдаачид цуглах
Саармаг хуурай тойрмыг хэн ч болов орхих гэжээ.

Түүнчлэн “Субашид”-ийн 169 дүгээр бадагт

Phan par smra ba dkon pa ste
De dag bas kyang nyan na dkon
Sman pa mkhas pa rnyed dka’ ste
De yi tshig bzhin byed pa nyung гэснийг

Зая бандид орчуулсан нь:

Тустай өгүүлэгч чухаг болох
Түүний тул тэд сонсох цөөн
Мэргэн эмч олдох бэрх
Түүний үг үйлдэх цөөн

Энэхүү бадагт хэрэгтэй тустай зүйлийг хэлж ярих хүн цөөн боловч үнэн зөв үгийг сонсох хүн бүр цөөн гэжээ. Энэ нь эрдэмтэй чадалтай сайн эмч ховор бөгөөд мэргэн эмчийн зааврыг чанд мөрдөх хүн ховор байдагтай агаар нэг юм гэсэн утгатай. Зая бандид энэ бадгийн үг хэллэгийг ягштал мөрдөж буулгасан байна. Мөнхүү бадгийг Цахар нутгийн гэвш Лувсанчүлтэм хөрвүүлсэн нь:

Үнэнхүү тустай бүхнийг зааж өгөгчин чухаг
 Үнэнээр түүнийг дагаж явагчин чухаг
 Үнэхээр өвчин бүхнийг таних эмч чухаг
 Үргэлж түүний үгээр явагчин чухаг

гэж толгой холбохын сацуу мөр бүрийн төгсгөлд “чухаг” хэмээх үгээр сүүл холбож уран яруу орчуулжээ.

“Субашид“-ийн бусад орчуулгаас Зая бандид ялгаа зөрөөтэй орчуулсан үг хэллэгийг харьцуулж үзье.

№	Төвөд хэлээр	Зая бандид	Сономгара	Цахар гэвш Лувсанчүлтэм
1	Byung po'i bya	бүдийн шувуу	элээсийн шувуу	шар шувуу
2	Dbyu gu	дэлэдвэр	дохиур	хэнгэрэг
3	Thabs brdugs kyang	муйрадавч	арга ядваас	арга мухардавч
4	Gos ser kyang	Шар дээлт	Вишнү	Вишнү
5	'khor los byur	Хүрдээр орчуулагч	Чакиравард	Загирвад
6	Lte ba	гийс	хүйс	хүйс

Дээрх жишээн дэх төвөд үг хэллэг, нэр томъёоны ялгаа зөрөөтэй орчуулга нь Зая бандидын орчуулгын онцлогийг харуулахаас гадна ойролцоо хэллэгийн хувилбар болох учир монгол хэлний үгийн сан судлалын хэрэглэгдэхүүн болно гэж үзэж байна. Оноосон нэрийн нэрийг (4-5 дугаар жишээ) Зая бандид төвөд хэлнээс үгчлэн буулгасан байна. Харин Сономгара болон Цахар гэвш нарын тухайд санскрит хэлээр сэргээн буулгах уламжлалт орчуулгын аргыг баримталжээ. Зая бандид төвөд орчуулагчид санскрит үг хэллэгийг орчуулж байсан уламжлалыг дагаж тийнхүү оноосон нэрийг орчуулсан байна. Өөрөөр хэлбэл, Зая бандид төвөд гүүш нарын орчуулгын арга зарчмыг даган мөрдөж байжээ (Reorich G.N, 1967, p.248).

Зая бандидын орчуулгад оновчтой хөрвүүлэг бас тааралдана. Тухайлбал, “Пагва шэйрав жи парол дү чин ба дорж жодба шэй жава тэгба чэнбой до”¹⁷ буюу товч нэрээр монголчуудын дунд “Доржжодба”¹⁸ хэмээх нэрээр танил болсон төвөд судрын нэрийг “Хутагт очироор огтлогч билгийн чанад хязгаараа хүрсэн нэрт их хөлгөн судар”, мөн “Хутагт билгийн чанад хязгаараа хүрсэн очироор эвдэгч нэрт их хөлгөн судар” гэж тус тус хөрвүүлсэн байдаг. Харин Зая бандид “Хутагт билгийн чанад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар” гэж ялгаатай орчуулжээ. Билгийн чанад хүрэх хэмээсэн тодотголтой бие, хэл, сэтгэлийн аливаа гэм хорыг очир алмааз мэт тасалж, ариун гэгээрлийн зам мөрт хөтлөхийг сургасан буддын гүн ухааны билиг барамидын 40 гаруй судрын нэг болох энэхүү бүтээл олон зүйл гар бичмэл, бар хэвлэлээр гадаад, дотоод улс орнуудын номын сан, хувь хүмүүсийн цуглуулгад хадгалагдаж байна.

Эртний Энэтхэгт аянга цахилгааны хүчийг Хурмаст тэнгэрийн очир (важра) хэмээх зэмсэгээр нэрлэж байснаас үүдэлтэй энэ нэрийн утгыг тодотгох

¹⁷ 'phags pa shes rab kyi pha rol tu phyin pa rdo rje bcod pa zhes by aba theg pa phyin pa'i mdo

¹⁸ Үгчилбэл дорж- очир, жодба- таслах, таслагч гэсэн утгатай.

“жодба” хэмээх үйл үгийг манай дуун хөрвүүлэгчид “эвдэгч”, “огтлогч”, мөн “гаслагч” гэх зэрэг буулгажээ. Уг сургаалын чанад утга бол би-д баримтлах үзлийг ор үндэсгүй арилгана гэсэн санаа бөгөөд энэхүү үйлийг очир алмаазтай зүйрлэсэн төвөд хэлний “доржжодба” (очир огтлогч) гэсэн хэллэгийг “гаслагч очир” хэмээн Зая бандид хөрвүүлсэн нь утгандаа дүйнэ. Харин “эвдэгч”, “огтлогч” гэж хөрвүүлэх нь зүйрлэгдэхүүн болох чулууны хаан очир алмаазын зэмсэгийн утга үүргийг сулруулна гэж бодож байна. Мөн “Хутагт билгийн чанад хүрсэн” гэсэн тодотголыг өгүүлбэрийн эхэнд найруулсан, “их хөлгөн” бус харин “их хөлгөний” (Махаяна) сургаал гэж харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр найруулсан тэргүүтэн нь уг судрыг бага (Хинаяна) бус харин их хөлгөний шашны сургаал болохыг тодотгоно. Түүнчлэн тус сударт санскрит хэлээр Анатхапиндада (төвөд хэлээр Гонмэдсайжин- mgon med zas sbyin) хэмээх Бурхан Будда-г ивээн тэтгэж байсан гэрийн эзний нэрийг Ширээт гүүш “Итгэл үгүй идээн өглөгт” гэж хөрвүүлсэн байдаг. Өглөгийн эзэн “итгэл үгүй” болсон нь төвөд хэлний “гон мэд”-ийн үгчилсэн орчуулгаас үүдэлтэй. Харин Зая бандид амь зуух итгэл найдваргүй болсон хүмүүст хоол хүнс өгдөг өгөөмөр хүн гэсэн санааг тодотгож “итгэл үгүйд идээ өгөгч” гэж өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр найруулсан нь оновчтой болсон гэж үзэж байна. (Poppe, 1971, p.161)

Ийнхүү үгчилсэн орчуулгын дэгийг тогтоосон Зая бандидын бүтээлд оновчтой хөрвүүлсэн баримт байхаас гадна шавь нарын хамт орчуулсан түүний бүтээл ойрад аялгууны үгийн сан, хэлзүй, найруулга, монгол орчуулгын түүхийг судлах чухал хэрэглэгдэхүүн болж байна. Монгол орчуулгын түүхийг баяжуулсан тод үсгийн орчуулгыг гадаад, дотоодын судлаачид судалж, хэвлэн нийтэлж олны хүртээл болгож буй нь цаашид ойрад аялгууны түүхийг судлахад зохих хувь нэмэр болох нь лавтай.

Ном зүй

1. Бүрнээ Д, 2003, “Занлүн” судрын монгол орчуулгуудыг хэл шинжлэлийн үүднээс харьцуулах нь, -Бүрнээ Д, Энхтөр Д, Уламжлалт орчуулгын судлалд, Улаанбаатар, Цээл-Эрдэнэ хэвлэл, х. 4-204.
2. Дэмчигмаа О, 2013а, “Субашид”-ын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог, Улаанбаатар, “Удам соёл” хэвлэх үйлдвэр.
3. Дэмчигмаа О, 2013б, “Субашид”-ын монгол орчуулгуудын галиг, үгсийн хэлхээ, Улаанбаатар, “Удам соёл” хэвлэх үйлдвэр.
4. Шагдарсүрэн Ц, 2017, Монгол хэлний олон аялгуунаа үгийн хэлбэр салаалан хөгжсөн нь/ Монгол хэл шинжлэл алтай судлал, эрдэм шинжилгээний чуулган, 1-р боть, УБ., “Соёмбо” хэвлэх үйлдвэр, х. 131-143.
5. Шагдарсүрэн Ц, 2001, Монголчуудын үсэг бичигийн товчоон, Улаанбаатар, Golden Eye Printing.
6. Рерих Ю.Н, 1967, Tibetan loan-words in Mongolian, - Избранные труды, Москва, изд. “Наука”, стр. 248-257.
7. Poppe N, 1971, The Diamond Sutra, Otto Harrasowith-Wiesbaden.